

## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XII НААДАМ

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1363 дугаар захирамж, “Эрүүл Монгол хүн” хөтөлбөр, “Соёлын бүтээлч аян”-ы хүрээнд Нийслэлийн иргэдийн спортын XII наадмыг 2024 оны 07 дугаар сараас 11 дугаар сарын 27-ны хооронд Дүүргийн Биеийн тамир, спортын хороод, Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран спорт явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, софт волейбол, хийн дасгал, аэробик, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр 5 үе шат (хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл)-тайгаар амжилттай зохион байгуулсан.



Энэхүү наадам нь багийн бүрэлдэхүүнд 31-ээс дээш настай нийслэлийн иргэн байх, тухайн төрлийн спортын дэд мастераас дээш цолтой тамирчин 45-аас дээш настай байх, наадмын нэг төрөлд нэг тамирчин орох, шалгарсан баг тамирчид үндсэн бүрэлдэхүүнээрээ шат шатны тэмцээнд оролцох зэрэг нь бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, хүн амыг биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулах, иргэдийн идэвх санаачлагыг өрнүүлэх, хөршийн холбоог сайжруулах зэрэг онцлог шинжтэй үйл ажиллагаа болсон.

Нийслэлийн иргэдийн спортын XII наадамд нийт 9 дүүргийн 204 хорооны 90100 иргэн оролцсон.

Нийслэлийн шигшээ тэмцээнд 71 хорооны 124 багийн 1044 иргэн оролцлоо. Нийслэлийн Шигшээ тэмцээний нэгдсэн нээлтийн арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Буян-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан.

Нээлтийн арга хэмжээг нээж Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд үг хэлж, Нийслэлийн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодын дарга нар оролцсон.



Нээлтийн арга хэмжээнд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбооны Э.Мөнх-Оргил, С.Ганчимэг нараар Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбооны тамирчид удирдуулсан “Аэробик гимнастик”-ийн үзүүлэх тоглолтыг хийсэн.



### СПОРТ ЯВГАН АЯЛЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын спорт явган аяллын шигшээ тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд Улаанбаатар-Налайх дүүрэг-Налайх дүүргийн Тайж хайрханы бэл-Улаанбаатар” чиглэлд автомашинаар 65 км, явган алхалтаар 10км туулж зохион байгуулсан.

Спорт явган аяллын тэмцээнд 73 хороо хорооны 1500 иргэд оролцсон.

Багийн нэгдсэн дүнгээр

1-р байранд Н.Мөнхбаяр ахлагчтай Баянгол дүүргийн 17-р хороо

2-р байранд Д.Дашцэнгэл ахлагчтай Сонгинохайрхан дүүргийн 4-р хороо

3-р байранд Э.Энхбаяр ахлагчтай Баянгол дүүргийн 17-р хороо тус тус шагналт байранд шалгарч цом, өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан.



### ОЛС ТАТАЛТЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын олс таталтын шигшээ тэмцээнийг Монголын олс таталтын холбоотой хамтран 2024 оны 11 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн “Хайрхан хөгжлийн төв”-ийн спортын зааланд зохион байгуулсан.

Нийслэлийн шигшээ олс таталтын тэмцээн 18 хорооны 18 багийн 360 тамирчин өрсөлдсөнөөс:

Эмэгтэй

1-р байранд Н.Наранцэцэг ахлагчтай Багануур дүүргийн 1-р хороо

2-р байранд Х.Эрдэнэцэцэг ахлагчтай Баянзүрх дүүргийн 13-р хороо

3-р байранд Ж.Отгонханд ахлагчтай Хан-Уул дүүргийн 21-р хороо

Эрэгтэй

1-р байранд Т.Мөнхзаяа ахлагчтай Сүхбаатар дүүргийн 11-р хороо

2-р байранд Д.Мөнх-Эрдэнэ ахлагчтай Хан-Уул дүүргийн 21-р хороо

3-р байранд Ш.Галбадрах ахлагчтай Чингэлтэй дүүргийн 16-р хороо тус тус шалгарч цом, өргөмжлөл, медаль мөнгөн шагналаар шагнасан.



## СОФТ ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Иргэдийн спортын XII наадмын софт волейболын шигшээ тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд “Буян-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан.

Шигшээ тэмцээнд 16 багийн 80 тамирчид өрсөлдсөнөөс:

1-р байранд Г.Цоож ахлагчтай Хан-Уул дүүргийн 21-р хороо

2-р байранд Г.Туяа ахлагчтай Налайх дүүргийн 8-р хороо

3-р байранд Д.Сүхбаатар ахлагчтай Баянзүрх дүүргийн 36-р хороо тус тус шалгарч цом, өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан.



## ШИРЭЭНИЙ ШАГАЙН НААДГАЙН ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын ширээний шагайн наадгайн тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд “Буян-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан. Ширээний шагайн наадгайн шигшээ тэмцээн нь морь уралдуулах, шагай шүүрэх, шагай няслах гэсэн 3 төрлөөр зохион байгуулж Нийслэлийн 9 дүүргээс шалгарсан 18 хорооны 18 багийн 288 тамирчид өрсөлдсөнөөс:

Эмэгтэй: 1-р байранд М.Мөнхзаяа ахлагчтай Багахангай дүүргийн 1-р хороо

2-р байранд Ж.Мөнгөнцэцэг ахлагчтай Хан-Уул дүүргийн 14-р хороо

3-р байранд Бадамханд ахлагчтай Багануур 5-р хороо

Эрэгтэй: 1-р байранд Б.Баатаржанчив ахлагчтай Багахангай дүүргийн 1-р хороо

2-р байранд С.Бямбацогт ахлагчтай Налайх дүүргийн 5-р хороо

3-р байранд Оджав ахлагчтай Багануур дүүргийн 4-р хороо тус тус шалгарч цом, өргөмжлөл, медаль мөнгөн шагналаар шагнасан.



## САГСАН БӨМБӨГИЙН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын сагсан бөмбөгийн шигшээ тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд “Буян-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан.

Нийслэлийн сагсан бөмбөгийн шигшээ тэмцээнд 18 багийн 432 тамирчид өрсөлдсөнөөс:

Эмэгтэй

1-р байранд Д.Отгонзаяа ахлагчтай Баянзүрх дүүргийн 23-р хороо

2-р байранд Эрдэнэбулган ахлагчтай Багануур дүүргийн 1-р хороо

3-р байранд Ж.Түмэнжаргал ахлагчтай Налайх дүүргийн 8-р хороо

Эрэгтэй

1-р байранд Ш.Азжаргал ахлагчтай Хан-Уул дүүргийн 10-р хороо

2-р байранд Б.Батзоригт ахлагчтай Багануур дүүргийн 3-р хороо

3-р байранд Г.Чингис ахлагчтай Баянгол дүүргийн 17-р хороо тус тус шалгарч цом, өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан.



## ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын волейболын шигшээ тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд “Буян-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан.

Нийслэлийн шигшээ тэмцээнд 18 багийн 360 тамирчид өрсөлдсөнөөс:

Эмэгтэй

1-р байранд М.Саруул ахлагчтай Сүхбаатар дүүргийн 7-р хороо

2-р байранд Г.Хишигт ахлагчтай Сонгинохайрхан дүүргийн 1-р хороо

3-р байранд Э.Эрдэнэ-Очир ахлагчтай Багануур дүүргийн 1-р хороо

Эрэгтэй

1-р байранд Д.Мөнхтулга ахлагчтай Хан-Уул дүүргийн 24-р хороо

2-р байранд Э.Эрдэнэ-Очир ахлагчтай Багануур дүүргийн 1-р хороо

3-р байранд П.Мөнхбаатар ахлагчтай Сүхбаатар дүүргийн 14-р хороо тус тус шалгарч цом, өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан.



## ХИЙН ДАСГАЛЫН ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын хийн дасгалын шигшээ тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын хийн дасгалын холбоотой хамтран “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан.

Нийслэлийн шигшээ тэмцээнд 9 багийн 108 тамирчид өрсөлдсөнөөс:

1-р байранд Сонгинохайрхан дүүргийн 14-р хороо

2-р байранд Чингэлтэй дүүргийн 6-р хороо

3-р байранд Хан-Уул дүүргийн 8-р хороо тус тус шалгарч цом, өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан.



## АЭРОБИКИЙН ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын аэробикийн шигшээ тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран “Буян-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан.

Шигшээ тэмцээнд 9 багийн 108 тамирчид өрсөлдсөнөөс:

1-р байранд Д.Ганбаатар ахлагчтай Баянгол дүүргийн 3-р хороо

2-р байранд Б.Ягаанцэцэг ахлагчтай Налайх дүүргийн 2-р хороо

3-р байранд А.Өлзийтогтох ахлагчтай Хан-Уул дүүргийн 21-р хороо тус тус шалгарч цом, өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнасан.

## ДАРТСЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын дартсын шигшээ тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 26-27-ний өдрүүдэд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоо, Монголын дартс сонирхогчдын холбоотой хамтран “Буян-Ухаа” спортын ордонд зохион байгуулсан.

Дартсын шигшээ тэмцээнийг эмэгтэй дан хос, эрэгтэй дан хос, баг гэсэн 3 төрлөөр зохион байгуулж, нийт 9 дүүргийн 27 багийн 108 тамирчид оролцсон.

Дартсын тэмцээнд шагналт байранд шалгарсан баг, тамирчид:

**Эмэгтэй хос**

1-р байранд Сүхбаатар дүүргийн 14-р хороо

2-р байранд Баянзүрх дүүргийн 27-р хороо

3-р байранд Багануур дүүргийн 1-р хороо

**Эрэгтэй хос**

1-р байранд Хан-Уул дүүргийн 15-р хороо

2-р байранд Баянгол дүүргийн 17-р хороо

3-р байранд Баянзүрх дүүргийн 24-р хороо Р.Ганбат

**Багийн төрөл**

1-р байранд Багануур дүүргийн 3-р хороо

2-р байранд

3-р байранд:Багануур дүүргийн 1 дүгээр хорооны баг тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын “Шилдэг хороо”-гоор Б.Байгалмаа засаг даргатай Хан-Уул дүүргийн 21-р хороо шалгарч өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын шигшээ тэмцээний багийн нэгдсэн дүнгээр:

- 1-р байранд Т.Уранчимэг даргатай Хан-Уул дүүргийн БТСХороо
- 2-р байранд Д.Мөнхбаяр даргатай Налайх дүүргийн БТСХороо
- 3-р байранд Г.Сүхбаатар даргатай Багануур дүүргийн БТСХороо
- 3-р байранд Д.Отгонсүрэн даргатай Баянзүрх дүүргийн БТСХороо тус тус шалгарч, алт, мөнгө, хүрэл медаль, өргөмлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР